

ОРШИЛ

Тус компани Булган аймгийн Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Түшиг сумдын нутагт MV-015465, MV-020622 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Анх олгогдсон MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайд АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016.08.02 ны 562 дугаар шийдвэрээр Засгийн газрын 2015 оны 120, 289 тогтоолоор хориглосон талбайтай давхцалгүй хэсэгт солбицолд өөрчлөлт оруулж MV-015465, MV-020622 гэсэн 2 тусдаа тусгай зөвшөөрөл болж өөрчлөгдсөн.

Тус компани өөрийн хөрөнгөөр 2016 оны 12 сараас 2017 оны 05 сар хүртэл дээрх 2 тусгай зөвшөөрлийн талбайг хамарсан Баруун Хужирын хөндийн дээд хэсгийн алтны шороон ордод хайгуулын ажил гүйцэтгэж хайгуулын ажлын үр дүнгийн тайланг УУХҮЯамны Эрдэс Баялгийн Мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 03 сарын 21 өдрийн ХХ-02-04 тоот хуралдаанаар хэлэлцүүлж АМГТГ даргын 2018 оны 05 сарын 04 өдрийн Н/16 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

Мөн MV-20622 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцөд тулгуурлан орд ашиглах ТЭЗҮ-ийг Уул уурхайн зураг төслийн “Цариг Ресурс” ХХК боловсруулж 2018 оны 06 сарын 20 ны өдөр АМГТГ-н ЭБМЗ –н Т/18-07-09 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж ордыг ашиглах ТЭЗҮ-г батлуулсан.

Улмаар “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажил”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” зэргийг “ЕАСС” ХХК -р гүйцэтгүүлсэн. Мөн 2019 оны 12-р сард MV-015465, MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбай тус бүрт “ГЕОЦЕНОЗ” ХХК-р Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгүүлсэн.

2020 оны 6-р сард “Мархал Тал” ХХК-иар MV-015465, MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайнуудыг дамнан орших Баруун хужиртын хөндийн дээд хэсгийн алтны шороон ордод Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгүүлсэн.

Уурхайн ашиглалтын явцад эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5917:2008, MNS5918:2008 стандарт нормуудыг баримтлан гүйцэтгэсэн. 2022 онд 5.4 талбай олборлолтонд, урьд 2020 онд олборлолт явуулсан 1В-ХV хэсэгшилд хиймэл нуур байгуулж хажууд нь 2.4 га талбайд шинээр гадаад овоолго үүсгэсэн. Мөн хуучин гадаад овоолго байсан талбайд дахин хөрсний овоолго үүсгэж ажилласан.

Баруун Хужирын уурхайн орчмын бүс нутаг нь Монгол орны хөрс газар зүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсжилтэй нутгийн Хангайн хөрсний дэд бүсийн хүрээнд Сэлэнгийн үржил шимт хөрсний тойрогт хамаарагддаг (Үндэсний атлас 2009) тул биологийн нөхөн сэргээлт хийхэд маш таатай нөхцөлтэй байдаг.

Тус компанийн зүгээс урд өмнөх талбайнуудад хийж гүйцэтгэж ирсэн ажлын туршлага дээр үндэслэн нөхөн сэргээлтийн ажлын явцад биологийн нөхөн сэргээлтийн ургамалжуулалтын ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй эрчимтэй хийж гүйцэтгэх ялангуяа тухайн бүс нутагт тохирсон ургамалжуулалтын агротехнологийг бий болгох зорилт тавьж нөхөн сэргээлт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага болох “Дэвжих Төгөл” ХХК, - тай 2013 оноос одоог хүртэл хамтран ажиллаж байна.

1. ТУХАЙН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уурхайн ажиллах горим. 2022 онд уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, уулын ажлын хэмжээ, ордын уул техникийн нөхцөл зэргээс хамааруулан ТЭЗҮ тусгагдсаны дагуу 3 сараас 10 сар хүртэл 245 хоногийн хугацаанд өдөрт 10-12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулсан.

2022 онд гүйцэтгэсэн уулын ажил. Баруун Хужиртын хөндийн дээд хэсгийн алтны шороон ордод энэ оны 3-р сарын 20 ноос бэлтгэл ажлыг хангаж 3-9 сарыг дуустал 7 сарын хугацаанд хөрс хуулалт болон элс олборлолт, нөхөн сэргээлтийн ажлуудыг явуулсан. Уурхай нь 1В-ХVII, 1В-ХVIII, 1В-ХIX, 2В-ХIII, 2В-ХIV, 2В-ХV, блокуудыг олборлох замаар MV-020622 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нөөц тооцоологдсон хэсэгшилүүдийн хойд хэсэгшил рүү өрнөсөн.



(Зураг № 1 2022 оны уулын ажил явагдаж буй байдал)

Үржил шимт хөрс хуулалт. 1В-ХVII, 1В-ХVIII, 1В-ХIX хэсэгшилийн 30.0 мян/м² талбайд 0.5 метр зузаантайгаар үржил шимт хар шороон хөрсийг бульдозероор түрж MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөхөн сэргээлт хийгдэж буй талбайд зөөвөрлөн тарааж нөхөн сэргээлтийн ажил зэрэг хийгдэж явсан. Нийт 15.0 мян/м³ үршил шимт хөрс хуулсан.



(Зураг № 2 Үржил шимт хар шороон хөрсийг хуулж буй байдал)

Хөрс хуулалтын ажил. Ил уурхайг нээх буюу эхлэх үед хөрс хуулалтыг экскаватор, бульдозер, автосамосвалын хослолоор урд оны олборлолт хийсэн хоосон орон зайг дүүргэж дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Дээд доод давхаргын хөрс хуулалтын нийт зузаан 10 м байна. Нийт 438.59 мян/ м³ хөрс хуулсан.

Элс олборлолтын ажил. Элс олборлолтын догол, мөрөгцөгийн өндөр нь элсний давхаргын зузаанаас шалтгаална. Олборлолтын ажлыг бульдозероор соёодож сийрэгжсэн хөрс, элсийг эксковатор, автосамосвалын хослолоор зөөвөрлөдөг. Ил уурхайгаас гарсан элсийг баяжуулах хэсгийн дэргэд зөөвөрлөн авч ирж элсний түр овоолго үүсгэдэг. Баруун Хужирын хөндийн алтны шороон орд нь уул техникийн нөхцөлийн хувьд цэвдэгтэй орд тул угаан баяжуулах элсийг гүйцэт гэссэний дараа баяжуулдаг онцлогтой юм. Тус орд нь хайгуулын ажлаар дээд доод гэсэн элсний 2 давхарга тогтоогдсон. 2022 онд нийт дээд давхаргын 1В-ХVII, 1В-ХVIII, 1В-ХIX, 1В-ХХ, доод давхаргын 2В-ХIV, 2В-ХV, 2В-ХVI гэсэн 7 хэсэгшилийн 181.93 мян/м³ элс угаан баяжуулсан. 2В-ХIII хэсэгшилийн 51,47 мян/м³ элсийг угаах төхөөрөмжийн хажууд овоолго үүсгэж үлдээсэн.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Тоосжилтыг бууруулах

Хөрс болон элсийг ачих, тээвэрлэх, буулгах үндсэн тоног төхөөрөмжүүд болон хөрсний овоолго, зам талбайгаас тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулахаас сэргийлж дараах арга хэмжээг авч ажилласан.

Экскаваторын ажлын үед:

- Хөрс хуулалтын ажлын үед болон элс олборлох үед мөргөцгийг болон ажлын талбайн гадаргыг услаж байсан.
- Бульдозероор замыг байнга хусч, тоос үүсгэж буй хөрс чулуунаас цэвэрлэж байх, замын нягтралыг ихэсгэх буюу бульдозер байнга ажиллуулсан.
- Уурхайн бүх хэсгийн автозам болон бусад зорчих хэсэг, талбайг үйлдвэрлэлийн явцад угаагдаж гарсан элс, шороогоор тавьж бэхжүүлдэг тул тоосжилт бага үүсдэг
- Карьеар угаах төхөөрөмж элсний овоолго хөрсний овоолго хүртлэх бүх технологийн замыг өдөр тутам тогтмол услаж ажилласан.
- 2022 онд шинээр 200 метр зам хийж мөн урьд онуудад ашиглагдаж байсан технологийн замыг ашигласан. Автосамосвалуудыг аль болох карьеартай ойр зайд зогсоол хийж ажилласан

Овоолго:

- 2022 онд шинээр 1В-ХV хэсэгшилд хиймэл нуур байгуулж хажууд нь 2.4 га талбайд шинээр гадаад овоолго үүсгэсэн. Мөн урьд онуудын шимт болон хучаас хөрсний овоолгийн талбайг ашигласан.
- Зам талбай овоолго гэх мэт техникийн хөдөлгөөнөөр тоосжилт их үүсэх газарт усалгааг өдөр бүр ажил эхлэхээс 30 минутын өмнө хийх шаардлагатай тохиолдолд ажлын явцад хийж ирсэн.

2. Хорт хийг бууруулах:

Баруун Хужирын уурхайд ажиллаж байгаа нийт 40ширхэг техникийн 2022 оны агаарын бохирдлын төлбөрийн Сэлэнгэ аймгийн татварын газарт төлсөн. Хүнд машин, механизмуудын дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа болон хорт хийг стандарт хэмжээнд байлгахын тулд утаа ихтэй техникийн янданд шүүлтүүр тавьсан. (Дезиль генератор, Экс SE-210, Экс Hyundai 520) Мөн Norht Benz автосамосвал 5ш, Экс Hyundai 850 хөдөлгүүрт үйлчилгээ хийсэн. Уурхайд ажиллаж байгаа бүх техник тоног төхөөрөмжид техникийн паспорт хөтлөж засвар үйлчилгээг цаг тухай бүрт нь тогтмол хийж ажилладаг.

Хүснэгт 1

2022 онд агаар мандлыг хамгаалах, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын хэмжээ түүний зардал

№	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжсэн хугацаа	Зардал мян/төг	Гүйцэтгэл
1	Уурхайн зам талбайг тогтмол услах тоосжилтийг багасгах.	2022 оны 3-9 сард	Үйл ажилагааны зардал	Тоосжилт хуурайшилт ихтэй үед замын усалгааг тогтмол хийж байсан.
2	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хувиарын дагуу хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх	2022 оны 3-9 сард	5000.0	Бүх техник тоног төхөөрөмжинд механик инженер хяналт тавьж утаа их гаргаж байгаа техник тоног төхөөрөмжийг засварласан. (Дезиль генератор, Экс SD-210, Экс Hyundai 520)
	Бүгд		5000.0	

Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Тухайн жилийн ашиглах усыг “УСНЫ ГАЗАР”-аар дүгнэлт гаргуулж Сэлэнгэ мөрний сав газрын захиргаатай “Ус ашиглах гэрээ” байгуулж ажилласан. Алт угаах зорилгоор байгуулсан нуур цөөрмийг олборлолт явуулсан хэсэгшлийн хоосон орон зайд байгуулсан.

- Технологийн усны чанар стандартанд хяналт тавьж ажилласан
- Мөн нууруудыг болзошгүй үерийн уснаас хамгаалж, хамгаалах зон татсан
- Технологийн ашигласан усны 100 % эргүүлэн ашигласан.
- 2017 онд “Эрдэнэ сүрвэй” ХХК-аар гүйцэтгүүлсэн энгийн хамгаалалтын бүсийн шав тэмдэгийн зарим муудсан хэсгийг засаж сайжруулсан. Мөн хил хамгаалах байгуулагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн хажууд тухайн цэгийн дугаарыг нүдэн харагдахуйц өндөр байрлуулан шинээр хийсэн. (Анх мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн булангийн цэг хэвээр байгаа)

Алт угаах процесст үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд олборлолт явуулсан талбайн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай зэрэгцүүлэн хийж ажилласан. Улирал тутам хөрс уснаас дээж авч Сэлэнгэ аймгийн МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ-д шинжилгээ хийлгэж хяналт тавьж ажилласан.

Дээрх шинжилгээнүүдийн хариуг хавсаргасан.



(Зураг № 3 Усны шинжилгээ авсан байдал)



(Зураг № 4 Унд ахуйн усыг хамгаалж хашаажуулсан байдал Зураг №5 Технологийн нуурнаас дээж авсан байдал)

Хүснэгт 2

2022 онд усан орчныг хамгаалах, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын хэмжээ түүний зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжсэн хугацаа	Зардал мян/төг	Гүйцэтгэл
1	Унд ахуйн болон технологийн уснаас дээж авч шинжлүүлэх	2022 оны 5,9 сард	Хяналт шинжилгээний зардалд оруулсан	Унд ахуйн болон технологийн уснаас сорьц авч Сэлэнгэ аймгийн МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН Лабораторид 5 цэгээс тус бүр 2 удаа сорьц авч 2022 оны 05, 09 сард шинжлүүлсэн (Хариуг хавсаргав)
2	Гол горхи болон усны эх үүсвэрийг эргэн тойронд үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдалаар бохирдохоос хамгаалан байнга хяналт тавьж ажиллах	Үйл ажилагааны явцад	500.0	Гол горхи болон усны эх үүсвэрийг эргэн тойронд үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдалаар бохирдохоос хамгаалах, ан амтан орохоос сэргийлж хашаа барьсан.
	Бүгд		500.0	

ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Хөрс хуулалтын ажлыг эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.5-1.0 м орчим зузаантай үржил шимт хөрсийг хуулж 3.5-м метрээс өндөргүй овоолго үүсгэсэн. Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцөлийг хангаж өгдөг.

Уурхайн сул орон зайг хөрсний дотоод овоолгоор дүүргэн тэгшилж техникийн нөхөн сэргээлтийг хийдэг. Ингэхдээ байгаль орчныг хамгаалах, ил уурхайд нөхөн сэргээлтийг хийх аргачлалын дагуу мөргөцгийн налууг 8-10 градус хүртэл багасгаж байгалийн унаган хэлбэр төрхөнд нь аль болох ойртуулж хэлбэршүүлдэг. Ингэснээр цаашид нөхөн сэргээгдсэн орчин нь бэлчээрийн нөөц болох боломж бүрдэнэ.

Уурхайн эдэлбэр талбайн хөрс тэнд явуулж буй ажил, үйлчилгээнээс хамааран шингэн, хатуу хог хаягдлаар бохирдох магадлалтайг харгалзан үзэж уурхайн орчинд буй хог хаягдлыг хатуу хуурай хог хаягдал, дахин ашиглах дугуй, ажилласан масло тос, төмөр хийцийн хог хаягдал зэргийн цэгүүдийг тус тусад байгуулан ажиллаж байгаа. Мөн жорлон, ахуйн бохир ус зайлуулах цэгийг “Ахуйн бохир ус зайлуулах дүрэм”-д заасны дагуу суурингийн салхин доод талд байрлуулсан. Мөн дахин ашиглагдах хогыг цуглуулах цэг байгуулж, уурхайн түр хогийн цэгт хураагдсан хогийг сумын төвлөрөсөн хогийн цэг рүү зөөвөрлөж уурхайн түр хогийн цэгийг үл нэвчүүлэх материал (HDPE) дэвсэж доторлосон.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа (тосгон, уурхай, шатахуун түгээх цэг, ус татамжийн байгууламж) объектуудад Монгол улсын ариун цэврийн хууль бусад журам, зааврын дагуу шаардлагатай байгууламжуудыг байгуулж ажиллаж байна. ШТМ-ын агуулахын талбайг үл нэвчүүлэх материал (HDPE) дэвсэж, угаagdсан хайргаар хучиж газрын гадарга бохирдохоос сэргийлдэг. Үйл ажиллагаанаас хамааран шаардлагатай зарим хэсэгт тусгай цементэн хатуу хучилт хийж ажилласан.



(Зураг № 6 Ахуйн хуурай хог хаягдал цуглуулах нүх Зураг №7 Дахин ашиглагдах хог)



(Зураг № 8 Үйлдвэрлэлийн хатуу хог, хаягдал төмөр Зураг №9 Ашигласан масло тос)

**ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**

Тухайн олборлолт явуулах талбайн үржил шимт өнгөн хөрсийг үйлдвэрлэлийн талбайн гадна талд тусгайлан овоолж бэлтгэсэн

Хөрсний овоолгыг нэг жилээс хэтрүүлэхгүйгээр нөхөн сэргээлтэнд ашигласан.

Мөн олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замыг эмх цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавьсан.

Уурхайд ажиллах машин бусад техникүүдийг шатахуун цэнэглэх, урсгал засвар хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд гүйцэтгэдэг.

Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадаглалтанд MNS 5916:2008 стандартыг, Уул уурхайн үйлдвэрлэлийг үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэнд MNS 5917:2008 стандартыг баримтлан ажиллаж байна. 2020 онд тос шатахуунаар бохирдсон хөрсний бохирдолтой хэсгийг хуулж эрүүлжүүлэх, нэмэлт бохирдол явагдахаас сэргийлж ШТМ-ын агуулахын 20X10м талбайг үл нэвчүүлэх материал (HDPE) дэвссэн.



(Зураг № 10 Ил уурхай, технологийн зам, үржил шимт хөрсний овоолго, хөрсний овоолго)

**УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**

Газрын гадарга хөрсийг элэгдлээс хамгаалахын тулд уурхайн тосгонд мод, сөөг суулгах, олон наст ургамал тарих, уурхайн эргэн тойронд хөрсний элэгдлээс хамгаалахад өдөр тутмын анхаарал тавьж ажиллаа.

Замгүй газраар тээврийн хэрэгсэл явж талхалдаг тул үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд угаагдсан элс хайргаар гол технологийн замыг байгуулж тус замаар уурхайн тээвэр явагддаг. Мөн карьеарт ойрхон авто зогсоол байгуулан, тэмдэгжүүлсэн.

Биологийн нөхөн сэргээлтийг Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал болон “MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран буюу зөвлөмж, заавраар гүйцэтгэдэг.

Нөхөн сэргээлт хийж тарималжуулахад доорхи ургамлын зүйлийг сонгох нь хөрсийг эвдрэлээс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрийг сайжруулах бөгөөд ингэснээр тухайн нутгийн ургамлан нөмрөг сэргэх, зүйлийн бүрдэл улам баялаг болох зэргээр экологийн тэнцэлд чухал үүрэгтэй гэж үзэж дараах мод ургамалыг тариалсан.

2022 онд нөхөн сэргээлтийн тариалсан ургамал модны төрөл зүйлүүд

Хүснэгт 3

д/д	Ургамлын төрөл	Нөхөн сэргээлт хийхэд ашиглах ургамлын төрөл зүйлүүд	Тариалсан мод бут ургамлын хэмжээ.
1	Бут сөөг	Бургас, чацаргана, шар хуайс, голт бор	Чацаргана 1500 ширхэг Нарс 300 ширхэг
2	Өвслөг ургамал	Өлөнгө, согоовор, ерхөг, биелэг өвс, царгас, гиш, хошоон, хунчир, харгана.	Согооворын үр 145 кг

Хүснэгт 4

Сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах төлөвлөсөн арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Нийт зардал, мян/төг	Гүйцэтгэл	
	1	2	3	8		9	
1	Агаарын чанар	Ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.	Төсөл хэрэгжүүлэхэд ашиглах бүх дотоод шаталтад хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл машин механизм	2022 оны үйл ажиллагааны явцад	5000	Бүх техник тоног төхөөрөмжинд механик инженер хяналт тавьж утаа их гаргаж байгаа техник тоног төхөөрөмжийг засварласан. (Дезиль генератор, Экс SD-210, Экс Hyundai 520)
		Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, хөрс элс тээвэрлэж буй машинаас тоосжилт үүсч болох	Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд услах, чийглэх замыг дагтаршуулах	Шороон замууд	2022 оны үйл ажиллагааны явцад	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	Тоосжилт хуурайшилт ихтэй үед замын усалгааг тогтмол хийж байсан.
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Технологид ашиглаж байгаа усыг тунгаан эргүүлэн ашиглах	Ус ашиглах хэсгүүд	2022 оны үйл ажиллагааны явцад	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	Ашиглалт явуулсан хоосон блокод урьд жилүүдэд ашиглагдаж байсан нуурын ус, мөн хавар цасны шар усаар дүүргэдэг хиймэл нуурыг үүсгэж технологийн усыг эргүүлэн ашигладаг.

		Гадаргын болон газрын доорх усанд бохирдолт үүсэх	Гол горхи болон усны эх үүсвэрийн эргэн тойронд үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдалаар бохирдохоос хамгаалан байнга хяналт тавьж ажиллах, ундны усны цэгийн хашааг сэргээн засварлах	Гол горхи усны эх үүсгэвэрт	2022 оны үйл ажиллагааны явцад	100	Уурхайн тосгоны зүүн хажуу амнаас урсах унд ахуйн усны хамгаалалтын хашааг сэргээн засварласан.
3	Хөрсөн бүрхэвч	ШТМ-ын агуулгын ойр орчмын хөрс шатах тослох материалын нөлөөгөөр бохирдох	ШТМ-н агуулхын ачаа буулгах талбайг хатуу хучилттай болгох, ойр орчимд болзошгүй аюулаас сэргийлж самбар тэмдэг тэмдгэлгээ, байрлуулах	Төслийн талбайн ойр орчинд	2022 оны үйл ажиллагааны явцад	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	ШТМ-ын агуулах, засварын талбай, Хатуу хог хаягдлын цэгийг цэгийн ойр орчмыг бохирдсон хөрсийг цэвэрлэж, угаагдсан эфиль гаалиар хучсан
4	Газрын хэвлий	Ашигт малтмалын нөөцийг төлөвлөлтгүй сорьцлон олборлох	Эрдэс баялгийн нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах ашигт малтмалын үед олборлолт, боловсруулалтын байгальд сөрөг нөлөө багатай хаягдалгүй технологи нэвтрүүлэх	Ордыг ашиглах явцад	2022 оны үйл ажиллагааны явцад	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	ТЭЗҮ тусгагдсаны дагуу тухайн онд олборлолт явуулах хэсэгшилээс бусад газарт газрын хэвлийг хөндөөгүй 2022 онд шинээр 2.4 га-д элсний овоолго үүсгэсэн. Шимт хөрс саарал хөрсний овоолгыг урьд онуудад нөлөөлөлд өртсөн талбайг эргүүлэн ашигласан.
5	Ургамалын нөмрөг	Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас ургамалын бүрхэвч доройтох	Шимт хөрсийг төлөвлөлтийн дагуу овоолго үүсгэж биологийн нөхөн сэргээлтийг норм стандартын дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн олборлотын болон нөлөөлийн бүсүүдэд	2022 оны үйл ажиллагааны явцад	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	2022 онд олборлолтонд өртсөн талбайн шимт хөрсийн тал хувийг шууд нөхөн сэргээлтэнд ашигласан. Үлдэгдэл 10 мян/м ³ хөрсөөр овоолго үүсгэсэн. Нийт 15.0 мян/м ³ үршил шимт хар шороон хуулсан.
6	Амьтны аймаг	Төсөл хэрэгжих орчны зэрлэг амьтад үргэх, дайжих	амьтны аймгийг хамгаалах, хууль бус агнуур явуулахгүй байх	Төслийн ойр орчин	2022 оны үйл ажиллагааны явцад	0	Ан ангуурын үйл ажиллагаа явуулаагүй
		Нийт				5100	

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг дараах байдлаар хийхээр төлөвлөсөн.

Техникийн нөхөн сэргээлт: Энэ онд MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2019 онд ашиглалт олборлолт явуулж 2021 онд хиймэл нуур болгон ашиглаж байсан 1В-XII хэсэгшилийн 2.0 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ.

Биологийн нөхөн сэргээлт. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 2 хэсэг газарт хийхээр төлөвлөсөн.

1. Биологийн нөхөн сэргээлтийг тавалсан гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2021 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 1.0 га-д биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн

2. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа MV-020622 тоот талбайнг 1В-XI блокын 2.0 га талбай, нийт 3.0 га талбайд 2022 онд үржил шимт хөрсөөр хучих, чацаргана, болон олон наст өрхөг согоовор, гэх мэт мод ургамал тарих зэргээр биологийн нөхөн сэргээлтийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу "Дэвжих төгөл" ХХК гүйцэтгэнэ гэж төлөвлөсөн.

Баруун Хужирын ордод нийт 2022 оны 09 сарын байдлаар MV-015465, MV-020622 тоот 2 тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 2010 оноос хойш 76.44 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн байна.

MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 47,5 га талбай уул уурхайн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөнөөс 47,5 га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн.

MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 27.64 га талбай уулын ажилд хамаарагдсанаас 2022 оны 09 сарын байдлаар 8,9 га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

Дээрх 2 тусгай зөвшөөрлийн талбайн нийт 76.44 га талбайгаас 56,4 га -д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн байна. Нийт 76,44 га талбайн 53,84 га талбай нь олборлолт явуулсан талбай, 22,6 га нь овоолго хэлбэрээр нөлөөлөлд өртсөн талбай юм.

1. Техникийн нөхөн сэргээлт

Баруун Хужиртын уурхайн хувьд үүсэх карьерын ихэнх хэсэг шууд дотоод овоолгоор нөхөн сэргээгдэх бөгөөд элс олборлолт, эфель галийг тээвэрлэн карьерийн ашиглагдсан орон зайд тарааж асгах, дотоод овоолгыг байршуулах зэрэг нь нарийн уялдаатай тодорхой дэс дараалалтай явагдахаараа онцлог юм. Энэ нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх, байгалийн унаган төрхийг аль болох хуучин хэвэнд нь оруулахад ихээхэн ач холбогдол бүхий ашиглалтын технологи юм.

Гадаад овоолгоос хөрсийг тээвэрлэн карьерын ашиглагдсан хоосон орон зайг дүүргэх, тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэрэг нөхөн сэргээлтийн ажилд экскаватор-автосамосвалын хослол, ковш, бульдозерыг ашигладаг.

2022 оны уулын ажлаар 5.4 га талбай хөндсөн, гадаад овоолго хэлбэрээр 2,4 га талбай нөлөөлөлд өртсөн. MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайд өмнөх 2018, 2019, 2020, 2021 онуудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд MV-020622 тоот талбайд олборлолтын үйл ажиллагаа явагдаж, уг тусгай зөвшөөрлийн талбайтай залгаа урьд 2015, 2016 онуудад олборлолт явуулсан MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайд нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж байсан. Энэ нь урьд онуудад олборлосон блокийн хоосон орон зайд дараа жил хиймэл нуур үүсгэн угаалга баяжуулалт, нэг талаас дотоод овоолгоор угаагдсан элс хайргаар дүүргэдэгтэй холбоотой юм.

MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах 1В-Х, 2С-II нөөцийн хэсэгшилийн 2019 онд ашиглалт олборлолт явуулж, 2020-2021 хиймэл нуур болгон ашиглаж байсан блокод дотоод овоолгийн 4.4 га техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нийт 665.1 мян/м³ уулын ажил гүйцэтгэсэн.

Техникийн нөхөн сэргээлтийн ажилд:

Hyundai 520LC-9 эксковатор -3 ш, CAT 950H утгуурт ачигч - 1ш,

Hyundai 300 LC эксковатор -1 ш, CAT 966H утгуурт ачигч - 1ш,

CAT D9r бульдозер - 2ш, North Benz 290r автосамосвал – 6 ш, тус тус ажилласан.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардал нь 1м³ уулын ажил гүйцэтгэх зардал нь 10-15 мян/төг гарч байгаа бөгөөд техникийн нөхөн сэргээлт нь хөрс хуулалт, элс олборлолт, баяжуулалтын явцад давхар хийгдэж байх тул үйл ажиллагааны зардалд тооцогдсон. Техникийн нөхөн сэргээлтийг хийхдээ “Дэвжих төгөл” ХХК-ийн мэргэжлийн зөвлөгөөг авч “Шар нарст” ХХК нь өөрийн техник хүн хүч зардлаар гүйцэтгэсэн.

2. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 2 хэсэг газарт хийсэн.

1. Баруун Хужирын хөндийн дунд хэсэгт орших MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах 2016 онд ашиглалт явуулсан 2018-2019 онд хиймэл нуур болгон ашиглаж байсан хэсэгшилийн дотоод овоолгийн 1.0 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж 500 ш чацарганы суулгац 25 кг согооврын үр тариалсан.

2. MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах 1В-Х, 2С-II хэсэгшилийн 2018 онд ашиглалт олборлолт явуулж 2019-2020 онд хиймэл нуур болгон ашиглаж байсан хэсэгшилийн хажуугийн гадаад овоолгийн 2.0 га талбайд биологийн нөхөн

сэргээлт хийж олон наст согооврын үр 45 кг, тариалсан. Мөн урьд жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд Чацарганы суулгац 1000 ширхэг, нарс 300 ширхэг, олон наст согооврын үр 75 кг -ийг тус тус тариалсан.

Биологийн нөхөн сэргээлтэнд тариалсан бут ургамлыг сонгон авахдаа:

- Байгаль цаг уур, хөрс болон геологи, гидрогеологийн нөхцөл, эвдрэлд орохоос өмнө ургаж байсан ургамлын төрх, газрын төрх
- Хөрсний овоолгыг бүрдүүлж байгаа чулуулгийн агрохимийн болон агрофизикийн шинж чанар
- Эвдрэлд орсон газрын эрүүл ахуйн нөхцөл
- Тус районы хүн амын суурьшил, цаашдын хөгжлийн хэтийн төлөв
- Хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлага зэрэг хүчин зүйлүүдийг тооцож сонгодог .

Уурхайн хувьд хүн ам нягт суурьшаагүй, Монгол орны хойд хилийн бүсэд оршдог, малын бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжтой зэргийг харгалзан олон наст ургамал тариалж биологийн нөхөн сэргээлт хийдэг.

Биологийн нөхөн сэргээлтийн олон наст ургамлын үр суулгах, мод, бут, сөөг, тарих, агротехникийн боловсруулалт хийх, арчилгаа тордолт хийх ажлуудыг туслан гүйцэтгэгч “ Дэвжих төгөл” ХХК гүйцэтгэдэг.

2022 онд MV-015465 MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайнуудад биологийн нөхөн сэргээлт тариалсан чацарганы суулгацыг “Дэвжих төгөл” ХХК-н баруун Хужиртын уурхай дээр үрслүүлж байгаа суулгацыг ашигласан.

Биологийн нөхөн сэргээлтийн талбайн мод бутны суулгац үр суулгах ургуулах арчилгаанд гарах зардлыг ажил гүйцэтгэх хамтран ажиллах гэрээний дагуу төлбөр тооцоо нь хийгдсэн.



(Зураг № 11 MV-020622 тоот талбайн нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал)



(Зураг № 12 MV-020622 тоот талбайд 2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал)



(Зураг № 13 MV-020622 тоот талбайд 2022 ононы 09 сар биологийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал)



(Зураг № 14 MV-020622 тоот талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдэж буй байдал 2022 оны 09 сар)



(Зураг № 15 MV-015465 тоот талбайд 2021 онд техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал 2021 оны 09 сар)



(Зураг № 16 MV-015465 тоот талбайд 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал 2022 оны 09 сар)

Хүснэгт 5

**Нөхөн сэргээлтийн талаар 2022 онд авч хэрэгжүүлсэн арга
хэмжээ түүний зардал**

№	Нөхөн сэргээлтийн төрөл	Төлөвлөсөн нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал сая/төг	Гүйцэтгэл
1	Техникийн нөхөн сэргээлт	Энэ онд MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 2019 онд ашиглалт олборлолт явуулж 2021 онд хиймэл нуур болгон ашиглаж байсан 1В-ХII хэсэгшилийн 2.0 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ.	га	4.4	Дотоод зардлаар гүйцэтгэсэн	MV-020622 тоот талбайд 4.4 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн
2	Биологийн нөхөн сэргээлт	Баруун Хужирын хөндийн дунд хэсэгт орших MV-015465 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах 2021 дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 1.0 га талбай, мөн MV-020622 тоот тусгай зөвшөөрлийн талбайн 1В-Х, хэсэгшилийн зүүн талд орших гадаад овоолгийн 2.0 га талбайд тус тус БНС хийнэ. 2022 онд 2 хэсэг талбайд нийт 3.0 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийнэ.	га	3.0	60.0	MV-015465 тоот талбайд 1.0 га-д биологийн нөхөн сэргээлт хийж 20.0сая/төг, MV-020622 тоот талбайд 2.0 га-д биологийн нөхөн сэргээлт хийж 40.0 сая/төг Нийт 3.0 га-д биологийн нөхөн сэргээлт хийж 60.0 сая/төг зарцуулсан
	Нийт				60.0	

4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд тусгай зөвшөөрлийн талбайн ТЭЗҮ, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хугацаа дуусаж байгаа тул үлдэгдэл нөөцийг төлөвлөгөөт онд бүрэн гүйцэт олборлох, уурхайн хаалтанд бэлтгэх, тавалсан гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу MV-015465, MV-020622 тоот талбайнуудын урьд жилүүдэд нөхөн сэргээлт хийсэн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах уурхайн хаалтанд бэлтгэх тусгай хамгаалалттай газар нутгийн чадавхи менежментийг сайжруулах чиглэлээр “Зэд Хантай Бүтээлийн нурууны” дархан газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллахаар төлөвлөсөн байсан.

Хүснэгт 6

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал сая/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Нөхөн сэргээлтийг сайжруулах	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт (тухайн нутагт дасан зохицсон ургамал тариалах)	Уурхайн хаалтанд бэлтгэх урьд жилүүдийн нөхөн сэргээлтийн чанар стандартыг сайжруулах чиглэлээр ажилласан.	8.0 га	Ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Дэвжих Төгөл” ХХК гүйцэтгэсэн.		2022 оны 3-10 сард	MNS 5915: 2008 MNS 5916: 2008 MNS 5917: 2008 MNS 5918: 2008
2	Шууд хамгаалах арга хэмжээ	ТХГ-ын чадавхи менежментийг сайжруулах	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны хүсэлтийн дагуу БО хяналтын цэг рүү явах замын ажил гүйцэтгэсэн.	400 метр		3.0	2022 оны 03-10 сард	-
	Нийт					3.0		

5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ , НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус ордын хувьд Монгол орны хойд хилийн бүсэд оршдог бөгөөд тухайн бүс нутагт уурхайгаас өөр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, оршин суугаа ард иргэн байхгүй. Тухайн орд нь Монгол улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид харшлах нөхөн олговор олгох ямар нэгэн зүйл энэ онд хийгдээгүй.

Хүснэгт 7

№	Нөлөөлөх өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлсэн хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Баруун Хужиртын хөндийн нь Монгол улсын хойд хилийн бүсэд оршдог. Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг тул тус ордын ойр орчим нөлөөлөлд өртөх иргэд байхгүй .	хийгдэхгүй	Үйл ажиллагааны явцад тодотгох	0	0	0	Ордын ашиглалтын нийт хугацаанд	Хилийн тухай хууль 2016 он
	Нийт			0	0	0		

6 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тусгай зөвшөөрлийн талбайн түүний ойр орчим түүх соёлын өвтэй холбоотой зүйлс байхгүй. Төсөл хэрэгжих явцад хөрсөн доороос хэрэв ямар нэгэн түүхэн болон археологийн зүйлс олдвол холбогдох байгууллагад мэдэгдэн хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулж илэрцийг /олдворыг/ хамгаалах болно. Энэ онд Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай тусгай хамгаалалтай газрын менежментийг сайжруулах тал дээр хамтран ажиллаж байна.

Хүснэгт 8

№	Нөлөөлөх өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая/төг	Нийт зардал сая/төг	Хэрэгжүүлсэн хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
